

АСОСАИ-н
СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
2022-2027

ТАНИЛЦУУЛГА

Аудитын дээд байгууллагын Азийн байгууллага (АСОСАИ) нь бүх гишүүн орнуудын дэмжлэгтэйгээр байгууллагын дөрөв дэх стратегийн төлөвлөгөө болох “2022-2027 оны Стратегийн төлөвлөгөө”-гөө танилцуулж байна. Энэхүү стратегийн төлөвлөгөө ерөнхийдөө өмнөх төлөвлөгөөнд тусгагдсан эрхэм зорилго, алсын хараа, үндсэн үнэт зүйлс, гурван стратегийн зорилгын талаарх мэдэгдлийг багтаасан болно.

Цар тахал, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн болон хүний хүчин зүйлсээс үүдэлтэй гамшиг, шинжлэх ухаан, технологийн дэвшлийг харгалзан үзэж АСОСАИ нь “Хариу арга хэмжээ авах” гэдгийг үндсэн үнэт зүйлдээ нэмсэн. АСОСАИ гишүүд байгууллагуудаа өөрсдийн бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлж, үндэсний засаглалын тогтолцоонд үр дүнтэй ажиллаж, улс орон болон ард иргэддээ илүү их үнэ цэнийг хүргэхийн тулд тулгарсан шинэ сорилтод хурдан бөгөөд зохистой хариу арга хэмжээ авч, уян хатан, тэсвэртэй байдлаа нэмэгдүүлж чадна гэж өндрөөр үнэлдэг.

ИНТОСАИ-н 2016-2022 оны стратегийн төлөвлөгөөтэй адил гурван стратегийн зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү төлөвлөгөөнд дөрвөн “нийтлэг тэргүүлэх чиглэл”-ийг тодорхойлсон.

Дөрвөн тэргүүлэх чиглэл нь *ИНТОСАИ-н Бээжингийн болон Москвагийн тунхаглал, АСОСАИ-н Ханойн болон Бангкокийн тунхаглалд* дэвшүүлсэн санаануудыг давтаж байна. Энэ нь олон улсын төрийн аудитын чиг хандлагыг дагаж, АСОСАИ-н бүс нутгийн онцлог, хөгжлийн хэрэгцээнд анхаарлаа төвлөрүүлэхийн зэрэгцээ олон улсын төрийн аудитын нийгэмлэгт идэвхтэй оролцох АСОСАИ-н санаачилгыг илэрхийлж байна.

Энэхүү төлөвлөгөөг уялдаатай байлгах, хэрэгжүүлэх уян хатан байдлыг хангах үүднээс зөвхөн ерөнхий болон зарчмын мэдэгдлүүдийг тусгасан бөгөөд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээллийг агуулаагүй болно. Энэ мэдээллийг АСОСАИ-н 2022-2027 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн матриц болгон нийтэд зарлах болно. АСОСАИ хэрэгжилтийн явцыг зохих ёсоор хянах, хэрэгжилтийн үр дүнг хянах, шаардлагатай бол энэхүү төлөвлөгөө болон хэрэгжилтийн матрицад нэмэлт, өөрчлөлт оруулах Стратегийн төлөвлөгөөний ажлын хэсгийг томилно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

АСОСАИ нь ИНТОСАИ-н мэргэжлийн, улс төрийн бус бүс нутгийн байгууллагын хувьд АСОСАИ-н бүс нутаг дахь төрийн аудитын салбарт чадавхыг хөгжүүлэх болон мэдлэг олгох үйл ажиллагаагаар дамжуулан өөрсдийн орнуудын сайн засаглал болон тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах, өндөр гүйцэтгэлтэй ажиллахад хүрэхэд нь гишүүн Аудитын дээд байгууллагууддаа дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

АЛСЫН ХАРАА

Гишүүн Аудитын дээд байгууллагууддаа сайн засаглалаа хөгжүүлж, бүс нутгийн мэргэжлийн байгууллага болоход нь дэмжих.

Энэхүү стратегийн төлөвлөгөөний дуусгавар болох 2027 он гэхэд АСОСАИ сайн зохион байгуулалттай чадавхыг дэмжих, мэдлэг хуваалцах болон бусад үйлчилгээнүүдийг хүргэхэд мэргэшсэн байх бөгөөд Аудитын дээд байгууллагууд нь өөрсдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мөн мэргэшсэн байна. АСОСАИ болон бусад гишүүн Аудитын дээд байгууллагууд нь бүс нутаг болон өөрсдийн улс орондоо сайн засаглалыг хөгжүүлэх үнэ цэнэ, ашиг тусыг дээшлүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛ

Мэргэшил, хамтын ажиллагаа, хүртээмжтэй байдал, шинэлэг/инновац, хариу арга хэмжээ авах

МЭРГЭШИЛ

АСОСАИ нь шударга ёс, ил тод болон хараат бус байдлыг эрхэмлэн ажиллана.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

АСОСАИ нь гишүүн Аудитын дээд байгууллагуудыг хамтарч ажиллахад нь тусалж, дэмжих болно.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

АСОСАИ нь харилцан хүндэтгэх, жендерийн тэгш байдлын зарчмыг баримтална. АСОСАИ гишүүдийнхээ олон талт байдлыг хүлээн зөвшөөрч, оролцооны тэгш боломжоор хангана.

ШИНЭЛЭГ БАЙДАЛ/ИННОВАЦ

АСОСАИ нь Аудитын дээд байгууллагууд, харилцагч талуудын хэрэгцээнд нийцсэн инновацыг эрэлхийлж, сорилтуудад хариу арга хэмжээ болон шинэ санаачилгуудыг дэмжихэд тодорхой эрсдэлийг хүлээх болно.

ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

АСОСАИ нь бүс нутгийн болон дэлхийн байгаль орчны өөрчлөлтөд хурдан хариу үйлдэл үзүүлж, учир холбогдолтой хэвээр байхын тулд шинээр гарч ирж буй сорилтод бэлэн байна.

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ:

ИНТОСАИ-н хамгийн сүүлийн үеийн тэргүүлэх чиглэлүүд болон гишүүн АДБ-уудын нийтлэг асуудлуудыг харгалзан үзсэн АСОСАИ-н анхаарлын төвд тулгуурласан Стратегийн зорилтууд нь АСОСАИ-г 2022-2027 он хүртэл хөгжүүлэх замыг тавихыг зорьж байна.

Стратегийн зорилт 1: Шинэлэг бөгөөд хариу арга хэмжээ авах чадавхыг хөгжүүлэх

Стратегийн зорилт 2: Чанарын мэдлэгийн үйлчилгээ

Стратегийн зорилт 3: Мэргэжлийн болон холбогдох бүс нутгийн байгууллага

НИЙТЛЭГ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

АСОСАИ нь үйл ажиллагаагаа өргөн хүрээнд зохион байгуулдаг стратегийн гурван зорилгыг дэмжих зорилгоор АСОСАИ-г ойрын жилүүдэд стратегийн зорилгодоо хүрэхэд үндэс суурь болгон дөрвөн үндсэн чиглэлийг тодорхойлсон.

Нийтлэг тэргүүлэх чиглэл 1: Аудитын дээд байгууллагуудыг сайн засаглалтай болоход нь дэмжлэг үзүүлэх;

Нийтлэг тэргүүлэх чиглэл 2: ТХЗ-ын зорилтод хүрэх Аудитын дээд байгууллагуудын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх;

Нийтлэг тэргүүлэх чиглэл 3: Технологийн дэвшлээс бий болсон боломжуудыг ашиглах;

Нийтлэг тэргүүлэх чиглэл 4: Тулгамдаж буй асуудал болон тулгамдаж буй нөхцөл байдлуудад хариу арга хэмжээ авах.

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1

ШИНЭЛЭГ БӨГӨӨД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЧАДАВХЫГ ХӨГЖҮҮЛЭХ

Стратегийн зорилтууд

1. АСОСАИ болон түүний гишүүн Аудитын дээд байгууллагуудын хэрэгцээнд тулгуурласан төрийн аудитын салбарыг цаашид хөгжүүлэхэд анхаарлаа хандуулах

Эдийн засаг, нийгмийн үлэмж хөгжил нь Аудитын дээд байгууллагуудын үйл ажиллагаа явуулдаг орчныг илүү бүрдүүлж өгсөн. Сайн засаглалын тухай ойлголтыг нийгэмд өсөж буй ойлголт болон технологийн хурдацтай хөгжлийн тухай *“Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр”*-ийг баталснаар Аудитын дээд байгууллагуудад боломж, саад аль алийг нь авчирсан.

Үндэсний засаглалын чухал хэсэг болохын хувьд Аудитын дээд байгууллагууд нь тус саадуудад арга хэмжээ авч, цаашдын чиглэлүүдэд анхаарлаа хандуулж ажилладаг:
Үүнд:

- Тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхэд хөндлөнгийн хараат бус хяналт тавих;
- Технологийн хөгжлийн арга хэмжээнүүд; болон
- Хариуцлага, ил тод байдлыг дэмжих.

АСОСАИ нь АСОСАИ-н Ханойн тунхаглал, ИНТОСАИ-н Москвагийн тунхаглалыг анхаарч, Тогтвортой хөгжлийн зорилгод зэрэг холбогдох асуудлуудад аудит хийх чадавхыг хөгжүүлэхэд анхаарч, энэ чиглэлээр аудит явуулахад АДБ-уудыг дэмжих болно. АСОСАИ нь өөрийн гишүүн АДБ-уудаа өөрчлөгдөж буй орчинд дасан зохицоход нь болон үр ашиг, үнэ цэнээ өгсөхөд нь дэмжлэг үзүүлнэ. Энэхүү ололт амжилтад хүрэхийн тулд АСОСАИ нь ИНТОСАИ болон бусад бүс нутгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, АСОСАИ-н хүрээнд нягт уялдаатай ажиллах болно.

2. Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн авчирч буй чадавхыг хөгжүүлэх гишүүн Аудитын дээд байгууллагуудын хувьсаж буй хэрэгцээнд арга хэмжээ авах

Хиймэл оюун ухаан, дата аналитик, цахим шилжилт зэрэг шинжлэх ухаан, технологийн дэвшил нь төрийн байгууллагын аудитын стратегийн чиглэл, аудитын арга зүйд улам хүчтэй нөлөөлж байна. Эдгээр чиг хандлагуудад үр ашигтай дасан зохицохын тулд АДБ-ууд технологийн дэвшлүүдэд суурилсан боломжуудад хариу арга хэмжээ авч, мэргэжлийн чадавхыг бэхжүүлэхэд идэвхтэй оролцоотой байх шаардлагатай. Эдгээр чадавхуудыг хөгжүүлэх үйл ажиллагааг АДБ-ууд эсвэл оролцогч талууд санаачилсан аль нэг талаас үл хамаарч АСОСАИ нь гишүүн АДБ-уудын хэрэгцээнд гарсан өөрчлөлтийн дагуу дараах байдлаар чадавхыг хөгжүүлэх ажлыг дэмжиж ажиллана:

- Аудитын зохих арга зүй, удирдамжийг боловсруулах, албан хаагчдыг сургах, аудитын чанарын баталгааг сурталчлахад АДБ-уудыг дэмжих;
- Гишүүн АДБ-ууд болон бусад оролцогч талуудын туршлага солилцох, хамтын ажиллагааг дэмжих;
- ИНТОСАИ-тай хамтран ажиллаж, АДБОУС-г багтаасан ИНТОСАИ-н бүтээгдэхүүнийг ашиглах.

3. Олон талт чадавхыг хөгжүүлэх санаачилгын хүрээнд “Ай Ди Ай”, бусад бүс нутгийн байгууллагууд болон академик нийгэмлэгүүдтэй хамтарч ажиллах

Үлгэр жишээ үзүүлэх зорилгоор АСОСАИ нь Тогтвортой хөгжлийн зорилгын аудит зэрэг төрийн секторын аудитын шинэ хөгжилд анхаарлаа хандуулах болно. АСОСАИ нь гишүүн АДБ-уудын төрөлжсөн хэрэгцээг илүү сайн ойлгох үүднээс суурь хэрэгцээнүүдийг шалгаж, АДБ-ын мэргэжлийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авна. Мөн АСОСАИ нь шинэлэг, бодит чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн хүрээнд “Хөгжлийн санаачилга” болон бусад бүс нутгийн байгууллага, эрдэм шинжилгээний нийгэмлэгтэй нягт хамтран ажиллах болно.

4. Чадавхыг хөгжүүлэх хүрээнд хүний нөөцийг хөгжүүлэх

АСОСАИ нь чадавхыг хөгжүүлэх асуудал хариуцсан АДБ-ын ажилтнуудыг чадавх, ялангуяа цахим сургалт гэх мэт онлайн шийдлүүдийг ашиглах чадварыг нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, АСОСАИ-н чадавхыг хөгжүүлэхэд шинэ нөөцийн хүмүүсийг сургах талаар авч үзэх болно.

5. Онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах

АСОСАИ нь хамтын нийгэмлэг, нийгмийн сүлжээ зэрэг онлайн шийдэл, харилцааны хэрэгслийг ашиглан чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлнэ. Нэмж дурдахад, онцгой байдлын үед чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэхийн тулд шинээр гарч ирж буй нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах зохих дүрэм, журмаар өөрийгөө хангана.

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2

ЧАНАРЫН МЭДЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Стратегийн зорилтууд

1. АСОСАИ-н бүтэц, зохион байгуулалтын чадавхыг ашиглаж, үр дүн, үр бүтээмжтэй мэдлэг, туршлагыг олж авах.

Энэхүү зорилтын хүрээнд Ассамблей, Удирдах зөвлөл, АСОСАИ сэтгүүл, АСОСАИ-н судалгааны төслүүд, семинарууд, АСОСАИ бага хурал, АСОСАИ-н цахим хуудас болон түүний ажлын хэсгүүдэд холбогдох үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

Ассамблей нь бүх гишүүн АДБ-аас бүрддэг бөгөөд гурван жилд нэг удаа хуралддаг. Үүний гол үүрэг нь: АСОСАИ-н зорилгод хүрэхэд шаардлагатай гэж үзсэн бодлогыг боловсруулах; өөрийн дүрэм, журмыг гаргах, чуулган болон бусад байгууллагуудын үйл ажиллагааны дүрмийг тогтоох; гишүүн байгууллагуудын жилийн санхүүгийн хувь нэмрийг тодорхойлох; АСОСАИ-н гурван жилийн төсвийг батлах; байгууллагатай холбоотой асуудлаар дээд эрх мэдлийн хувьд шийдвэр гаргах; Удирдах зөвлөл, Тамгын газарт тодорхой үүрэг даалгавар өгөх, Удирдах зөвлөлийн дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга, гишүүдийг дотроосоо сонгох, Удирдах зөвлөлд харьяалагдахгүй гишүүдийг Аудитын хороог бүрдүүлэхэд өөрсдийнхөө дундаас сонгох, Байгууллагын дансны талаарх аудитын хорооны тайланг батлах.

УДИРДАХ ЗӨВЛӨЛ нь АСОСАИ-н гүйцэтгэх нэгж бөгөөд дараах үүргүүдийг хариуцаж ажиллана. Үүнд: Ассамблей-аар батлагдсан АСОСАИ-н дүрэм журмуудын хүрээнд бодлогуудыг хэрэгжүүлэх; тусгай зоригло болон төсөлд зориулсан хороог томилж, хороо тус бүрийн ажиллах дүрэм журмуудыг батлах; АСОСАИ-н жилийн санхүүгийн төлөвлөгөө, төсөв, түүний гүйцэтгэлийг батлах, Ассамблейд өргөн мэдүүлэх гурван жилийн төсвийг батлах; байгууллагын дансны тайланг авч үзэх; Удирдах зөвлөлийн чуулганы завсарлагааны хугацаанд даргын гаргасан акт, шийдвэрийг соёрхон батлах; Ассамблейн дараагийн төлөөлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга, АСОСАИ-н төлөөлөгчдийг ИНТОСАИ-н Удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх; Ассамблейн хурал болгонд үйл ажиллагааныхаа тайланг тавих

АСОСАИ-н СЭТГҮҮЛ нь бүх гишүүн байгууллагуудын дунд мэдлэг, туршлагаа хуваалцах үр дүнтэй суваг юм. Сэтгүүл нь чиг үүргээ сайжруулахын тулд сүүлийн стратегийн хугацаанд цаасан түгээлтээс цахим хэлбэр рүү шилжиж, өргөн хүрээний сэдвийг хамруулж байна. Ирэх жилүүдэд нийтлэлийн чанар, шинэчлэгдсэн сэтгүүлийн цахим хуудаст илүү хялбар нэвтрэх боломжийг сайжруулахын тулд ихээхэн хүчин чармайлт гаргах болно.

АСОСАИ СУДАЛГААНЫ ТӨСЛҮҮД нь АСОСАИ-н аудитын чадавхыг хөгжүүлэхийн тулд гишүүн АДБ-уудын харилцан сонирхсон, анхаарал хандуулж буй аудитын онолын болон практик асуудлуудын судалгааг дэмжих зорилготой юм. АСОСАИ нь гурван жил тутамд нэг судалгааны төсөл явуулдаг бөгөөд төслийг дуусгах зорилгоор судалгаа, ярилцлага, улс орны баримт бичиг, багийн гишүүдийн хэд хэдэн уулзалт зохион байгуулахаар төлөвлөдөг. АСОСАИ цахим хуудаст нийтлэгдсэн судалгааны төслийн үр дүн нь удирдамж бэлтгэхээс эхлээд улс орны туршлага, шилдэг туршлага, зөвлөмжийг баримтжуулсан төслийн тайланг гаргах хүртэл өөр өөр байдаг. АСОСАИ нь гишүүн АДБ-уудын илүү их оролцоог дэмжих, гишүүн АДБ-ын хэрэгцээнд тулгуурласан төслийн сэдвүүдийг илүү анхаарч, судалгааны төслийн эцсийн тайланг гишүүн АДБ-уудын хооронд хуваалцах, ашиглах замаар судалгааны төслүүдийн ач холбогдол, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор судалгааны төслүүдээ оновчтой болгох арга хэмжээг авах юм.

СЕМИНАРУУД нь АСОСАИ-д мэдлэг солилцоход зохих талбар болсон. Сүүлийн хэдэн арван жилд АСОСАИ-н нэгээс хоёр семинарыг хамгийн их анхаарал татсан, сонирхолтой сэдвүүдээр жил бүр зохион байгуулж, мэдлэгийг бүх гишүүддээ түгээж, үр өгөөжөө өгч ирсэн. Сүүлийн жилүүдэд АСОСАИ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан ИНТОСАИ-н бүс нутгийн байгууллагуудад АСОСАИ-н семинарууд нээгдэж байгаа нь гишүүн АДБ-уудад бусад бүс нутгийн туршлагаас суралцах боломжийг олгодог. Ирэх стратегийн төлөвлөгөөний хугацаанд АСОСАИ нь зардлаа нөхөх үндсэн дээр АДБ-аас олон оролцогчдын хүсэлтийг харгалзан үзэж, семинарын ач холбогдол, үр нөлөөг нэмэгдүүлэх, семинарын үргэлжлэх хугацааг уртасгах, цахим суурьтай шийдлүүдийг ашиглан тасралтгүй харилцан туршлага солилцох боломжоор хангах, семинарын дараах үр дүнг дагаж мөрдөх, чадавхыг хөгжүүлэх хөтөлбөрүүдтэй холбох юм. Цахим семинар зэрэг шинэ аргуудыг ашигласнаар гишүүн АДБ-ын аудитуудад хүртээмжтэй болж, ашиг тусаа өгөх болно. Түүнчлэн АСОСАИ нь ажлын байгууллагуудаа (хороод, ажлын хэсэг, ажлын хэсэг гэх мэт) илүү өргөн хүрээний сэдвүүдийг хамруулан семинар зохион байгуулахыг зорьж байна.

АСОСАИ БАГА ХУРЛЫГ гурван жил тутамд чухал, өргөн хүрээтэй сэдвүүдээр Ассамблейн үеэр зохион байгуулдаг. АСОСАИ нь бага хурлыг илүү идэвхтэй харилцан үйлчлэл, оролцоо, санал бодлоо хуваалцах боломжийг бүрдүүлэх талаар анхаарч үзнэ. Бага хурлын сэдвийн талаарх хамтарсан мэдэгдлийг нэг төрлийн үр дүн гэж үзэж болно.

АСОСАИ-н ЦАХИМ ХУУДАС нь мэдээ, мэдээлэл, цахим баримт бичиг, гишүүн АДБ-уудад урьдчилсан онлайн бүртгэл, судалгааны үйлчилгээ үзүүлдэг АСОСАИ-н цахим мэдээлэл, мэдлэг хуваалцах платформ юм. Гишүүн АДБ-уудын харилцан сонирхсон асуудлуудыг цаг тухайд нь, өндөр чанартайгаар хэлэлцэх онлайн форум болж ажиллах болно.

1. Гишүүн АДБ-уудын харилцан сонирхсон мэргэжлийн төрөл бүрийн асуудалд анхаарч ажлын хэсгүүдийг байгуулдаг. Ажлын хэсгүүд нь АСОСАИ-д зориулсан мэргэжлийн стандарт, удирдамж, шилдэг туршлагыг нэгтгэн дүгнэж болох тодорхой асуудлуудын судалгааг хөнгөвчлөх боломжтой. АСОСАИ нь судалгааны төсөл, семинар, чадавхыг хөгжүүлэх хөтөлбөрүүдийн сэдвүүдийг хооронд нь холбохыг оролдох бөгөөд ингэснээр эдгээр үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх боломжтой болно.

2. Гишүүн АДБ-уудыг үндэсний болон бүс нутгийн хүрээнд мэдлэг солилцох механизмыг судалж, бий болгоход дэмжлэг үзүүлэх.

Гишүүн АДБ-уудын дунд мэдлэг солилцох үйл явцыг үр дүнтэй, үр ашигтай болгохын тулд АСОСАИ нь АДБ-уудыг түнш хоорондын харилцан ашигтай хамтын ажиллагаа болон түүний үйл явцыг дэмжиж ажиллана. Тодорхой салбарт чадавх нь хөгжсөн АДБ-ууд бусад гишүүн АДБ-уудын хэрэгцээг дэмжиж ажиллана.

Аудитын мэргэжлийг тогтвортой хөгжүүлэхэд залуу аудиторууд чухал үүрэгтэй байна. АСОСАИ нь гишүүн АДБ-уудын хэрэгцээнд тулгуурлан хамгийн сүүлийн үеийн туршлага, дэлхийн алсын хараатай залуу аудитын мэргэжилтнүүдийг төлөвшүүлэх, хөгжүүлэх зорилготой гишүүн АДБ-ын залуу аудиторуудад зориулсан платформ байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү платформ нь гишүүн АДБ-ын залуу аудиторуудад стратегийн сэтгэлгээ, цогц чадавх, цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой харилцаа холбоо, аудит, технологийн ур чадвараа сайжруулах боломжийг олгоно.

3. Гишүүн АДБ-ууд, оролцогч талууд болон ИНТОСАИ-н хооронд мэдлэг, сургамж, шилдэг туршлагыг хуваалцахад дэмжлэг үзүүлэх, хэрэгцээнд суурилсан дэмжлэгийг цаг алдалгүй, үр дүнтэй хүргэх.

АСОСАИ нь төрийн хэвшлийн аудиттай холбоотой мэдлэг, шилдэг туршлагыг нэгтгэж, АДБ-ын хамтын ажиллагаа, тасралтгүй сайжруулалтыг дараах байдлаар дэмжинэ:

- Гишүүн АДБ-ын хэрэгцээг судлах, цуглуулах холбогдох механизмыг бий болгох;
- АСОСАИ-н гишүүд болон оролцогч талуудын хооронд өргөн мэдлэг, туршлага солилцох боломжийг олгох;
- Гишүүн АДБ-ууд, судалгааны байгууллагууд, ИНТОСАИ болон бусад бүс нутгийн байгууллагуудтай харилцан сонирхсон асуудлаар эрэлт хэрэгцээтэй туршлага судлах, судалгаа хийх;
- Гишүүн АДБ-уудыг шилдэг туршлага, сургамжаа хуваалцахад урамшуулах.

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ХОЛБОГДОХ БҮС НУТГИЙН БАЙГУУЛЛАГА

Стратегийн зорилтууд

1. Ирээдүйн хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор гишүүн АДБ-уудын дунд "Мэргэжлийн мэдэгдлийн олон улсын хүрээ"-г сурталчлах.

ИНТОСАИ-н "Мэргэжлийн мэдэгдлийн олон улсын хүрээ" нь төрийн хэвшлийн аудитын найдвартай байдал, хамаарлыг нэмэгдүүлж, олон нийтийн ашиг сонирхлын үүднээс АДБ-ын үр дүнтэй үйл ажиллагааг дэмждэг. Олон улсын мэргэжлийн стандартыг хэрэглэснээр АСОСАИ-н гишүүн АДБ-уудад үнэ цэнэ, ашиг тус нэмэгдэх болно. Тиймээс АСОСАИ нь гишүүн АДБ-уудын хэрэгцээнд тулгуурлан "Мэргэжлийн мэдэгдлийн олон улсын хүрээ"-г сурталчлах, хөнгөвчлөх, "Мэргэжлийн мэдэгдлийн олон улсын хүрээ"-н ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулах болно.

2. АСОСАИ-н бүтэц зохион байгуулалтыг сайжруулах замаар хариуцлагыг бататгаж, үйл ажиллагааны үр ашиг, мэргэшлийн нөөцийг нэгтгэх.

Бүс нутгийн жишиг байгууллага болохын тулд АСОСАИ нь АСОСАИ-н үйл ажиллагааны үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын хөгжилд илүү их анхаарал хандуулж, дараах байдлаар олон төрлийн аргаар ажиллана.

- Шаардлагатай бол АСОСАИ-нхууль, АСОСАИ-ийн дүрэм, журам болон бусад зохицуулалтуудыг хянаж, нэмэлт өөрчлөлт оруулах;
- Үйл ажиллагааг оновчтой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх, хариуцлагыг баталгаажуулахын тулд шаардлагатай бол АСОСАИ-н зохион байгуулалтыг (бүх ажлын байгууллагуудыг оролцуулан) хянаж, бүтцийн өөрчлөлт хийх;
- Стратегийн төлөвлөгөөг илүү сайн удирдлагатай хэрэгжүүлэх үүднээс Стратегийн төлөвлөгөөний ажлын хэсгийг бэхжүүлэх;
- Гишүүнчлэлийн жилийн хураамжийг баталгаажуулах, илүү олон гишүүн АДБ-аас сайн дурын хандивын бололцоог судлах, гишүүн АДБ-ын хэрэгцээ, хараат бус байдлыг харгалзан гадны доноруудыг урих замаар санхүүгийн тогтвортой байдалд хүрэх.

3. ИНТОСАИ, бусад бүс нутгийн байгууллагууд болон харилцагч талуудтай стратегийн харилцаагаа тогтворжуулж, бэхжүүлэх.

АСОСАИ нь ИНТОСАИ-н харьяа байгууллагууд (Хороо, дэд хороо, ажлын хэсэг гэх мэт), бусад ИНТОСАИ-н бүс нутгийн байгууллагууд болон НҮБ-ын харьяа байгууллагууд гэх мэт гадаад байгууллагуудтай хамтын ажиллагаагаа тэлнэ. Үүнээс гадна АСОСАИ нь олон улсын аудитын нийгэмлэгийн тасралтгүй хөгжилд хувь нэмрээ оруулах ИНТОСАИ болон бусад байгууллагуудын санаачилгад идэвхтэй оролцох болно.

НИЙТЛЭГ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД 1

АДБ-УУДЫГ САЙН ЗАСАГЛАЛТАЙ БОЛОХОД НЬ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

1. Дотоод засаглалыг сайжруулахын тулд гишүүн АДБ-уудын дунд АДБ-ын “Гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоо”-г нэвтрүүлэх, ашиглах

АДБ-ын “Гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоо”-г ашиглах

Хэдийгээр АДБ-ын “Гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоо”-ашиглах нь сайн дурын үндсэн дээр боловч АСОСАИ нь гишүүн АДБ-ын үнэ цэнийг дээшлүүлэх үнэлгээ, гүйцэтгэлийн хэрэгсэл болгон АДБ-ын “Гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоо”-г сурталчлах болно. АДБ-ууд нь АДБ-ын “Гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоо”-г тогтвортой гүйцэтгэлийн өсөлттэй холбоотой хараат бус байдал, хуулиар олгогдсон бүрэн эрх, аудитын ажлын чанар, болон дотоод бүтэц зохион байгуулалтын тогтолцоог хэмжих хэрэгсэл болгон ашиглах эрмэлзэлтэй байна.

Бүс нутгийн онцлог хэрэгцээ, нөхцөл байдалд дасан зохицохын тулд АСОСАИ нь бүс нутгийн АДБ-ын “Гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоо”-г хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, түүнд тохирсон арга барилыг боловсруулах талаар судалж байна. АДБ-ын дарга нар болон үнэлгээний мэргэжилтнүүдийг сургах зэрэг АДБ-ын “Гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоо” үнэлгээнд хангалттай дэмжлэг үзүүлэх болно. АДБ-ын найдвартай, өндөр чанартай “Гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоо” үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах байдлыг хангахын тулд гишүүн АДБ-уудын хэрэгцээнд үндэслэн хянан шалгах механизмыг бий болгоно.

2. Гишүүн АДБ-уудын хараат бус, ил тод, шударга байдлыг сайжруулах

Хараат бус байдал нь АДБ-уудын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд болон өөрийн улсын ард иргэдэд үр ашигтай, үнэ цэнтэй, өндөр чанартай үйлчилгээг хүргэхэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл юм. АДБ-ууд нь өөрсдийн хараат бус, ил тод, шударга байдлыг тогтвортой байлгах үүднээс тасралтгүй ач холбогдол өгч байх шаардлагатай. Гэсэн хэдий ч зарим АДБ-д аудитын хангалттай нотлох баримтыг олж авахад саад бэрхшээл байсаар байгаа бөгөөд аудитын хангалттай нөөц байхгүй байна.

АСОСАИ нь гишүүн АДБ-уудтай нягт хамтран ажиллаж, хараат бус бүрэн эрх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хангалттай нөөцтэй байхын тулд дэмжлэг үзүүлнэ. Мөн АСОСАИ нь чадавхыг хөгжүүлэх, мэдлэг хуваалцах үйл ажиллагаагаар дамжуулан мэдээлэл солилцох, хувь нэмрээ оруулах замаар гишүүн АДБ-уудын хараат бус, ил тод, шударга байдлыг сайжруулах сайн туршлагыг тодорхойлж, сурталчлах болно.

3. Үндэсний засаглал дахь АДБ-уудын стратегийн үүрэг

Сайн засаглалтай болоход АДБ-ын үүрэг оролцон нэн чухал байдаг. АДБ-ууд хараат бус, бодитой дүгнэлт гаргаж, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хариуцлагыг хангах, гүйцэтгэлийг дэмжих, авлигатай тэмцэх замаар үндэсний сайн засаглалыг сайжруулах, шударга ёсыг нэмэгдүүлэхэд тусалж чадна. АДБ-ууд нь өөрсдийн стратегийн үүргийн хувьд сайн засаглалыг дээшлүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгч, өөрсдийн бүрэн эрхийг бүрэн хэрэгжүүлэх ёстой. АСОСАИ нь гишүүн АДБ-уудыг ийм стратегийн хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, АДБ-уудын мэдлэг хуваалцах, хамтын ажиллагааг дэмжихэд туслалцаа үзүүлнэ.

НИЙТЛЭГ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД 2

ТХЗ-ЫН ЗОРИЛТОД ХҮРЭХ АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮЧИН ЧАРМАЙЛТАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

1. ТХЗ-той холбоотой мэдлэг солилцох, АДБ-уудын чадавхыг хөгжүүлэх

АСОСАИ нь ТХЗ-д хүрэх хариуцлагатай байдлыг дэмжихийн тулд ТХЗ-уудтай холбоотой аудит хийх замаар гишүүн АДБ-уудыг үүргээ биелүүлэхэд нь дэмжиж ажиллана. АСОСАИ нь АСОСАИ-н ТХЗ-ын ажлын хэсэг болон гишүүн АДБ-уудаар дамжуулан ТХЗ-д хамаарах тодорхой асуудлуудын талаар илүү сайн ойлголттой болох, АДБ-уудын хооронд мэдээлэл, туршлага солилцох, удирдамж болон бусад мэдээллийн материалыг хэвлүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх болно.

2. ТХЗ-ууд дахь үндэсний хэрэгжилтийн аудитууд

АСОСАИ нь чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагаа, мэдлэгийн үйлчилгээ үзүүлэх замаар гишүүн АДБ-уудаа дараах байдлаар дэмжин, нэг болон түүнээс дээш ТХЗ-ын зорилтуудтай холбоотой үндэсний хэмжээнд тохирсон зорилтод хүрэхэд хувь нэмрээ оруулна:

- ТХЗ-д хүрэх явцын талаар тайлагнах үндэсний тогтолцооны бэлэн байдлыг үнэлэх;
- ТХЗ-ын тодорхой асуудалд хувь нэмрээ оруулах төрийн гол хөтөлбөрүүдийн хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг үнэлэх зорилгоор гүйцэтгэлийн аудит хийх;
- ТХЗ-д хүрэхүндэсний засгийн газруудын хэрэгжилтийн явцыг хянах, үнэлэх зорилгоор бодит цагийн аудит хийх;
- ТХЗ-д хүрэхзасгийн газрыг үр дүнтэй ажиллуулахад саад учруулж болзошгүй эрсдэлийг илрүүлэх; болон
- Аудитын дүгнэлтийг цаг тухайд нь тайлагнаж, Засгийн газарт цаашид авах арга хэмжээ авах талаар илүү бодитой зөвлөмж гаргах.

3. ТХЗ-той холбоотой АСОСАИ-н бүс нутгийн хамтарсан аудит

Байгаль орчин, жендер, ядуурлын асуудлаарх хэлэлцүүлэг нь гишүүн АДБ-уудад үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд ТХЗ-д хүрэхэд хувь нэмрээ оруулах боломжийг олгодог. АСОСАИ нь ТХЗ-уудтай холбоотой хамтын аудитыг дэмжиж, дараах чиглэлээр оролцож буй АДБ-уудтай уялдаа холбоотой ажиллахад тусална.

- Эдгээр үйл ажиллагааг дэмжих зохих журам, тогтолцоог боловсруулах амлалт бүхий АДБ-уудын хамтарсан аудитын дэмжих;
- Аудитын нөлөө, аудитын үр дүнгийн хэрэгжилтийн талаарх АДБ-ын мэдлэгийг дээшлүүлэх; болон
- ТХЗ-уудтай холбоотой аудитын шилдэг туршлага, удирдамжийг гишүүн АДБ-уудын дунд түгээх.

НИЙТЛЭГ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД 3

ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛЭЭС БИЙ БОЛСОН БОЛОМЖУУДЫГ АШИГЛАХ

1. Шинэ технологийн ашиглалтын шинэ аудитын арга зүй

Big data аналитик, хиймэл оюун ухаан, blockchain, 5G гэх мэт шинэ технологиуд нь төрийн хэвшлийн аудит болон аудитаар шалгуулагч аль альд нь өндөр нөлөө үзүүлж байна. Гар ажиллагааны хэлбэрээр явагддаг байсан ажлууд нь мэдээллийн технологиор хурдацтай солигдож байгаа нь аудитын аргуудыг шинэчлэхэд хүргэж байна. АДБ-ууд эдгээр технологийн хөгжилд идэвхтэй арга хэмжээ авч, аудитын чадавхыг нэмэгдүүлэх боломж болгон ашиглах ёстой.

Аудитын шинэ аргуудын хэрэглээ нь гишүүн АДБ-д харилцан адилгүй байна. АСОСАИ нь гишүүн АДБ-уудыг технологийн хөгжилд дасан зохицож, гүйцэтгэлийг сайжруулахын тулд зохих арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлнэ.

2. Аудитын зохион байгуулалтын хэлбэрийг хувьсан өөрчлөгдөж буй аудитын арга зүйг сайжруулах замаар хувьсгах

Дээр дурдсанчлан, төрийн хэвшлийн аудит нь шинжлэх ухаан, технологиор тодорхойлогддог бөгөөд энэ нь АДБ-уудад гүйцэтгэлээ сайжруулах боломжийг олгодог. Шинэ технологи нь ажлыг илүү уян хатан аргуудыг бий болгож, аудитын зохион байгуулалтын хэлбэрт гүнзгий нөлөө үзүүлэх болно. Аудитын ажлыг аудиторуд газар дээр нь гар аргаар хийдэг байсан бол одоо өгөгдөлд дүн шинжилгээ хийх багууд хэсэгчлэн хуваалцдаг. АДБ-д талбарын ажлыг багасгах замаар Big data аналитик судалгаа хийх нь ашиг тустай. АДБ-ууд аудитын гүйцэтгэлийг сайжруулахын тулд шинэчлэгдсэн аудитын аргуудтай аудитын зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, алсын зайнаас аудит хийх үр дүнтэй платформыг бүрэн дижитал эринд бэлтгэх талаар анхаарч үзэх хэрэгтэй. АСОСАИ нь гишүүн АДБ-уудад энэ талаар туршлага солилцох боломжийг олгоно.

3. Аудитын зохион байгуулалтын хувьсгалын загвар бүхий аудитын онолуудыг судлах

Аудитын онолууд нь аудитын практик хөгжихийн хэрээр хөгжиж байгаа тул аудитын хөгжлийн чиг хандлага нь төрийн байгууллагын аудитад онолын шинэ арга зүйг судлах шаардлагатай болж байна. АСОСАИ ийм аудитын чиг хандлагыг тодорхойлох, шилдэг туршлагыг нэгтгэн дүгнэж, холбогдох судалгааны тайланг боловсруулахад илүү их анхаарал хандуулах болно. АСОСАИ нь аудитын онолд үнэ цэнийг нэмэхийн тулд олон талт мэдлэгийг хуваалцах, нэгтгэх зорилгоор эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран судалгаа хийж болно. Үүний нэгэн адил АСОСАИ нь шинэлэг аудитын лабораторийг эхлүүлэхийн тулд мэргэжлийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой.

НИЙТЛЭГ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД 4

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

1. Үндэсний болон олон улсын хэмжээнд анхаарал хандуулж буй эрсдэлийн бүсүүдийг тодорхойлж, эрсдэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх

Санхүүгийн хямрал, байгалийн томоохон гамшиг, халдварт өвчин, хүрээлэн буй орчны аюул, кибер аюулгүй байдал зэрэг шинээр гарч ирж буй асуудлууд нь хүн төрөлхтний нийгэмд томоохонхохирол үзүүлж болзошгүй юм. АДБ-ууд нь үнэ цэнэ, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд шинээр гарч ирж буй сорилтуудыг тодорхойлж, хариу арга хэмжээ авах чадвартай байх ёстой. АСОСАИ нь АСОСАИ болон түүний гишүүдэд нөлөөлж болзошгүй шинээр гарч ирж буй асуудлуудыг цуглуулах, хянах зохих механизмыг бий болгоно. АСОСАИ нь гишүүн АДБ-уудыг мэдлэгээ хуваалцах, техникийн дэмжлэг үзүүлэх замаар шинээр гарч ирж буй сорилтуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. Мөн АСОСАИ нь шинээр гарч ирж буй асуудлуудын талаарх ИНТОСАИ-н Хяналтын хороотой хамтран ажиллаж, шинээр гарч ирж буй асуудал, эрсдэлийг шийдвэрлэхэд АДБ-ын чадавхыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.

2. АДБ-ын үнэ цэнэ, ашиг тусыг таниулах

АДБ-уудыг хараат бус байдлыг нь алдагдуулахгүйгээр үндэсний зорилтоо илүү үр дүнтэй, хариуцлагатай биелүүлэхэд хувь нэмрээ оруулахыг уриалж байна. АДБ-ууд чухал, стратегийн асуудлаар аудитын зөвлөмж өгөх замаар төрийн секторын аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжтой.

АСОСАИ нь мэргэжлийн хамтын ажиллагааг дэмжих байдлаар үр дүнтэй, шинэлэг, холбогдох аудитыг дэмжихэд ач холбогдол өгч, гишүүн АДБ-уудад байгууллагын чадавхыг хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, шинэ боломж, сорилтуудыг шийдвэрлэхэд нь туслах болно.

3. АДБ-ын сорилттой орчинд тэсвэрлэх чадвар

Ковид-19-тэй холбоотой сорилтууд дэлхий дахинд ихээхэн нөлөөлсөн. АДБ-ууд алсын зайнаас ажиллах горимд бүрэн буюу хэсэгчлэн байдлаар шилжиж, алсын зайн аудитад дасан зохицох, тоон технологи ашиглах, ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, төрийн худалдан авалтад мэргэшсэн аудит хийх зэрэг хүчин чармайлтуудыг гаргаж шуурхай ажилласан. Бэрхшээлтэй байгаа хэдий ч эдгээр нөхцөл байдал нь бүтээлч байдал, шинэчлэлийг өдөөдөг. АСОСАИ нь гишүүн АДБ-уудыг мэргэжлийн чадавхыг тасралтгүй дээшлүүлэх, аудитын зохих арга, арга техникийг өөрчлөх, онцгой байдлын үед цаг тухайд нь хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлнэ.

ХАВСРАЛТ 1: АСОСАИ-н тухай

Түүх

АСОСАИ нь 1979 онд 11 гишүүнтэй байгуулагдсан. Эдгээр гишүүнчлэл нь онцгой эрхт гишүүд, гишүүд, туслах гишүүдээс бүрдэнэ. АСОСАИ-н гишүүнчлэлийн тоо одоогоор 47-д хүрээд байна.

Перу улсын Лима хотноо 1977 онд зохион байгуулагдсан 09 дүгээр ИНСОСАИ-н Филиппин Улсын Аудитын дээд байгууллагын дарга, ноён Тантуйко-гийн санал болгосноор АСОСАИ нь байгуулагдаж байсан түүхтэй. 1978 оны 10 дугаар сард Ази тив дахь Аудитын дээд байгууллагуудын ёсөн дарга Баруун Германы Берлин хотноо Германы Олон Улсын Хөгжлийн Сангаас зохион байгуулсан семинарт оролцсон бөгөөд АСОСАИ-н дүрмийг баталсан. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Шинэ Дэли хотноо 1979 оны 05 дугаар сард зохион байгуулагдсан анхдугаар чуулган бөгөөд Удирдах зөвлөлийн уулзалт зохион байгуулагдаж байсан. Тус чуулганы үеэр АСОСАИ-н анхны дүрэм, журмууд батлагдсан байдаг.

Зорилт

АСОСАИ-н зорилтод дараах заалтууд багтана:

- Төрийн аудитын чиглэлээр санал, туршлага солилцох замаар гишүүн байгууллагуудын ойлголцол, хамтын ажиллагааг дэмжих;
- чанар, гүйцэтгэлийг сайжруулах үүднээс төрийн аудиторуудыг чадавхжуулах, тасралтгүй боловсрол олгох нөхцөлөөр хангах;
- Төрийн аудитын чиглэлээр дэлхийн бусад улс орнуудын байгууллагуудтай мэдээллийн төв, бүс нутгийн холбоос болж ажиллах;
- Тухайн гишүүн байгууллагуудын засгийн газар болон бүс нутгийн бүлгүүдийн үйлчлэлийн аудиторуудын хоорондын нягт хамтын ажиллагаа, ах дүүгийн харилцааг дэмжих.

Үйл ажиллагаа

АСОСАИ-н чиг үүрэг нь:

- Ссудалгааг дэмжих, сурталчлах, аудит болон холбогдох чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл, мэргэжлийн өгүүлэл нийтлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн аудитын чиглэлээр санал, туршлага солилцох хурал, семинар зохион байгуулах;
- Зорилгодоо нийцүүлэн шаардлагатай бусад чиг үүргийг гүйцэтгэх.

Ассамблей/ чуулга

Чуулган нь бүх гишүүн АДБ-аас бүрддэг бөгөөд гурван жилд нэг удаа хуралддаг. Гол үүрэг нь:

- АСОСАИ-н зорилгод хүрэхэд шаардлагатай гэж үзсэн бодлогыг боловсруулах;
- АСОСАИ-н дүрэм, журмыг тогтоох, АСОСАИ-н чуулган болон бусад байгууллагуудын үйл ажиллагааны дүрмийг тогтоох;
- Удирдах зөвлөлийн дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга, гишүүдийг дотроосоо сонгох.

Удирдах зөвлөл

Удирдах зөвлөл нь АСОСАИ-н гүйцэтгэх байгууллага юм. Гол үүрэгт нь:

- Ассамблейгаас баталсан дүрэм, журмын дагуу АСОСАИ-н бодлогыг хэрэгжүүлэх;
- АСОСАИ-н жилийн санхүүгийн төлөвлөгөө, төсөв, түүний гүйцэтгэлийг батлах, чуулганд өргөн мэдүүлэх гурван жилийн төсвийг батлах;
- Ассамблейн хурал болгонд үйл ажиллагааныхаа тайланг тавих.

Нарийн бичгийн дарга

Хэрэг эрхлэх газрыг Ассамблейгаас сонгогдсон Ерөнхий нарийн бичгийн дарга удирддаг. Нарийн бичгийн дарга нарын газар нь АСОСАИ-д захиргааны дэмжлэг үзүүлж, байгууллагын санхүүгийн асуудлыг удирддаг.

Чадавхыг хөгжүүлэх удирдлага

Чадавхыг хөгжүүлэх удирдлага нь Удирдах зөвлөлийн удирдлага дор, Ерөнхий нарийн бичгийн даргатай нягт хамтран ажиллаж, АСОСАИ-н чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж, дагаж мөрдөнө. Чадавхыг хөгжүүлэх удирдлагыг Удирдах зөвлөлөөс томилж, Удирдах зөвлөлийн албан тушаалын гишүүн болно.

Аудитын хороо

Аудитын хороо нь чуулганаас сонгогдсон хоёр гишүүнээс бүрдэнэ. Хороо нь гурван жилд нэг удаа байгууллагын дансанд аудит хийж, тайлангаа чуулганд гаргадаг.

ХАВСРАЛТ 2: Гишүүнчлэл болон тунхагласан дотоод бүлгүүд

АСОСАИ нь ИНТОСАИ-н Бүс нутгийн ажлын хэсгийн хувьд гишүүн АДБ-уудыг бүс нутгийн олон ажлын хэсэгт нэгдэхийг зөвшөөрсөн хэвээр байгаа ИНТОСАИ-н гишүүнчлэлийн талаарх бодлогыг дэмжиж байна. Дараах хүснэгтэд Удирдах зөвлөлийн суудлын хуваарилалт, “Ай Ди Ай”-н бүс нутгийн болон бусад чадавхыг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдах эрх зэрэг INTOSAI-ийн түвшний асуудлуудтай холбоотой АСОСАИ-н гишүүдийн Бүсийн Ажлын хэсгийн гишүүд болон 2021 оны байдлаар зарласан гэр бүлийг харуулав.

д/д	Гишүүн орнууд	Бүс нутгийн ажлын хэсгийн гишүүнчлэл	Харьяалагдах байгууллага
1.	Афганистан	АСОСАИ	
2.	Австрали	АСОСАИ, ПАСАИ	ПАСАИ
3.	Азербайжан	АСОСАИ, ЕВРОСАИ	ЕВРОСАИ
4.	Арабын Нэгдсэн Эмират	АСОСАИ, АРАБОСАИ	АРАБОСАИ
5.	Армен	АСОСАИ, ЕВРОСАИ	ЕВРОСАИ
6.	Бангладеш	АСОСАИ	
7.	Бахрейн	АСОСАИ, АРАБОСАИ	АРАБОСАИ
8.	Бруней	АСОСАИ	
9.	Бутан	АСОСАИ	
10.	Вьетнам	АСОСАИ	
11.	Гүрж	АСОСАИ, ЕВРОСАИ	ЕВРОСАИ
12.	Израйл	АСОСАИ, ЕВРОСАИ	ЕВРОСАИ
13.	Индонез	АСОСАИ	
14.	Ирак	АСОСАИ, АРАБОСАИ	АРАБОСАИ
15.	Иран	АСОСАИ	
16.	Йемен	АСОСАИ, АРАБОСАИ	АРАБОСАИ
17.	Йордан	АСОСАИ, АРАБОСАИ	АРАБОСАИ
18.	Казахстан	АСОСАИ, ЕВРОСАИ	ЕВРОСАИ
19.	Камбож	АСОСАИ	
20.	Катар	АСОСАИ, АРАБОСАИ	АРАБОСАИ
21.	Кипр	АСОСАИ, ЕВРОСАИ	ЕВРОСАИ
22.	Киргизстан	АСОСАИ	
23.	Кувейт	АСОСАИ, АРАБОСАИ	АРАБОСАИ
24.	Лаос	АСОСАИ	
25.	Маврики	АСОСАИ, АФРОСАИ	АФРОСАИ
26.	Малайз	АСОСАИ	
27.	Малдив	АСОСАИ	
28.	Монгол	АСОСАИ	
29.	Мьянмар	АСОСАИ	
30.	Непал	АСОСАИ	
31.	Оман	АСОСАИ, АРАБОСАИ	АРАБОСАИ